

*Б.Мягмарсүрэн-ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын академийн 8062-р дамжааны
суралцагч, дэд хурандаа*

*Ц.Бямбарагчаа - ХСИС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага,
стратегийн профессорын багийн профессор,
доктор (PhD), хурандаа*

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ
ЗУДЫН ГАМШГИЙН ТУХАЙ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЗАРИМ АСУУДАЛ**

Хураангуй: Монгол улсад сүүлийн жилүүдэд тохиолдож байгаа гамшгийн төрлүүдээс хамгийн ихээр хохирол учруулж байгаа байгалийн гаралтай буюу зудын гамшиг нь улс болоод олон улсын анхаарал татах асуудлын нэг болсоор байгаа учраас энэхүү сэдвийг судлан танилцуулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Зудын гамшгийн тухай ойлголт, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйл, төрөл, урьдчилан сэргийлэх арга зам,

Оршил: Дэлхий дээр тохиолдож байгаа гамшиг, байгаль цаг агаарын гарвалтай аюулт үзэгдэл болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй осол, аваар жилээс жилд өсөн нэмэгдэж түүнээс учрах хор уршгийн нөлөө, үр дагавар улам бүр нэмэгдэж байгаа эдгээр аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох асуудал хурцаар тавигдаж байгаа бөгөөд улс орон бүр өөр, өөрийн эдийн засаг, нийгэм, байгаль цаг уур, хууль эрх зүйн орчинтойгоо уялдуулан төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Монгол улсын хувьд авч үзвэл Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа гэсэн түвшинд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үе шатуудад хийгдэх олон тооны үйл ажиллагаа, арга хэмжээний цогц ойлголт юм.

Гамшгаас хамгаалах менежментийн гамшгийн өмнөх түвшинд болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх үе шат хамаарна. Энэ үе шатны үндсэн зорилго нь гамшгийн эрсдэлийг бууруулах замаар гамшгаас үүсч болзошгүй сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн үед шуурхай ажиллах бэлэн байдлыг хангахад оршдог.

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь гамшиг үүсгэх онц аюултай объектууд, экологи, байгалийн аюултай үзэгдлүүдийг ажиглах, хүрээлэн байгаа орчны

төлөвт мониторинг хийх, хууль эрх зүй, зохион байгуулалт, эдийн засаг, инженер техник, экологийн хамгаалалт, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээнүүдийг тусгасан цогц бодлого хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаанаас тогтдог.

Үндсэн зорилго нь боломжтой тохиолдолд аюулт үзэгдэл үүсэхээс сэргийлэх, эсвэл нийгмийн эмзэг байдлыг бууруулах замаар хохирлын хэмжээг багасгах явдал юм. Энэ үйл ажиллагааны хүрээнд хийгдэх ажлын нэг нь Зудын гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх, малчдын эмзэг байдлыг бууруулах, болзошгүй зудын гамшгийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээнүүд хамаардаг.

Үндсэн хэсэг:

Зудын гамшгийн тухай ойлголт: Дэлхийн болон Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн улмаас зудын давтамж ойртож, түүний үр нөлөө улам ноцтой шинжтэй, үндэсний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлөл үзүүлэх төлөвтэй байгааг харгалзан, эрсдэлийг оновчтой үнэлж, бууруулах менежментийг сайжруулах арга замыг тодорхойлох асуудал ач холбогдолтой хэвээр байгаа юм¹. Улирлаар үргэлжлэх уур амьсгалын аномали нөхцөл (**стандар нөхцөлөөсөө хазайсан**) буюу ган, зудын асуудал Монголын бэлчээрийн мал аж ахуйн хувьд онцгой байр суурь эзлэнэ. Хахир хатуу өвлийн тухай ойлголт дэлхий дээр түгээмэл боловч зудын тухай ойлголт зөвхөн бэлчээрийн мал аж ахуйтай, жилийн 4 улиралтай нутагт л яригддаг².

Монгол орны нутаг дэвсгэрт олон удаа зуд болж, үүнээс улбаалан мал ихээр хорогдон хошуу хотлоороо үгүйрч байсан тухай түүхэн бичиг сударт 2000-аад жилийн өмнөөс тэмдэглэн үлдээсэн байдаг ба зуд гэж чухам юуг хэлэх вэ, түүнийг хэрхэн яаж тодорхойлох талаар шинжлэх ухааны үндэстэй судалгаа шинжилгээний ажлууд ч хийгдсээр байна.

Дэлхий нийтэд түгээмэл тохиолддог байгалийн 30 гаруй аюулт үзэгдлээс манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, хүчтэй салхи шуурга. цөлжилт, аянга, аадар бороо, үер, хүн, малын олон улсын хөл хориот гоц халдварт өвчний тархалт зэрэг байгалийн гаралтай 10 гаруй аюулт үзэгдэл, ой. хээрийн түймэр, нисэх онгоцны сүйрэл, гол, нуурын мөсний цөмрөлт, уурхайн осол, дэлбэрэлт, гүний нууралт, химийн хорт бодисын алдагдал, хордуулалт, объектын гал түймэр болон автотээврийн хэрэгслийн томоохон осол зэрэг хүний буруутай үйл ажиллагаа, техникийн холбогдолтой осол гарч, хүний амь

Ш.Болдбаатар. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам. УБ., 2016., х16.

Ш.Болдбаатар. Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам. УБ., 2016., х 17.

нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин сүйрч, нийгэм, эдийн засагт ихээхэн дарамт болж байна.

Манай оронд тохиолдож буй байгалийн аюулт үзэгдэл, ослын давтамж, түүний улс орны эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь дэлхий дахиныг хамарсан уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсын Их хурлаас 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн шинчилсэн найруулга батлагдан гарсан бөгөөд түүнд гамшгийн нэр томъёоны талаар тодорхой авч үзсэн. Үүнд:

“Гамитг” гэжАюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн нөөц, боломжоос давсан хохирол учрах¹ гэж тодорхойлсон.

Монгол улсад 2004-2017 онд жилд дунджаар аюулт үзэгдэл 3200 гаруй удаа, осол 171 удаа, давхардсан тоогоор 601 сум, дүүргийг хамран тохиолдож, түүнд 200 орчим хүн амь нас алаж, эдийн засаг, экологид 95 *тэрбум 645.4 сая* төгрөгийн хохирол учирсныг өмнөх 8 жилтэй харьцуулбал 10 гаруй дахин² өссөн үзүүлэлт тоо баримтаар гарч байна.

“Аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг³; гэж тодорхойлсон.

Монгол орны хувьд нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол үзүүлдэг байгалийн гамшгийн нэг төрөл нь “Зуд”-ын гамшиг юм. Гамшгийн холбогдолтой нэр томъёо тодорхойлолт MNS 6010:2009 стандарт зааснаар **ЗУД** гэж(*Zud disaster*) *"Их цас унах. эрс хүйтрэх, мал сүрэг өвс, усаар гачигдах зэргээр өвөл, хаврын улиралд мал сүрэг бэлчээрээр өл залгаж чадахгүй зутран турж үй олноороо үхэж хорогдоход хүрэх цаг уурын нөхцөл бүрдэх"*-ишт ойлгодог. Зуд болох үндэс нь зуны улиралд хур тундас бага орох мөн бэлчээрийн даац хэтэрсэнээс гадна цасан шуурга, эрс хүйтрэлт зэрэг байгалийн үзэгдлээс мөн хамаардаг.

Тухайлбал: Монгол орны нутаг дэвсгэрт сүүлийн 60 гаруй жилийн 65%-д нь их бага хэмжээтэй зуд тохиолдож байсан бөгөөд статистик судалгаанаас үзэхэд тохиолдож буй зудын улмаас жил тутам дунджаар 1,3 сая толгой мал хорогдож байна. Харин 1944-1945 онд 8,3 сая, 1950 онд 3,5 сая, 1967-1968 онд 2,9 сая, 1976-1977 онд 2,1 сая, 1999-2002 онд 11,2 сая, 2009-2010 онд 9,7 сая.

¹ Монгол Улсын гэмшгаас хамгаалах тухай хууль. УБ., 2017 он.

² Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын статистикийн эмхэтгэл УБ., 2004-2017.,

³ Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль. УБ., 2017 он

2015-2016 онд 1.02 сая, нийт 38,7 сая толгой мал хорогдож байжээ¹. Энэ нь 2016 оны жилийн эцсийн нийт малын 63 хувийг эзэлж байгаа тооцоог судлаачид гаргасан^{1 2}.

Зудын гамшиг үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйл:

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1,2-ын Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим гэсэн бүлгийн 1,2,5-ын “Бодитой хандах” гэсэн хэсэгт “болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц, боломжийг үр дүнтэй дайчилна³” гэж заасныг үндэс болгон зудын гамшигийн аюул, эрсдэлийг бодитой тодорхойлж, ялангуяа зудын Үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн салбар ялангуяа мал аж ахуй нь Монгол улсын уламжлалт ахуй, соёлын үнэт өв, эдийн засаг, нийгмийн чухал салбар бөгөөд Монгол Улсын ДНБ-ний томоохон хувийг эзэлдэг. Малчдын хувьд амьдралаа залгуулах, ажилгүйдлээс хамгаалах гол хэрэгсэл болдгоос гадна хот, хөдөөгийн хүн амын тэнцвэртэй байдлыг хадгалахад хөдөө аж ахуйн салбар чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Гэхдээ Монгол улсын эдийн засагт чухал үүрэгтэй бэлчээрийн мал аж ахуй нь байгалийн хараат байдалтай, байнгын эрсдэл дагуулж байдаг онцлогтой бөгөөд малчдын нэлээд хувь нь ядуурлын түвшингөөс доогуур, эсвэл ядуурлын түвшинд тун ойрхон амьдардаг учраас тэднийг нийгмийн эмзэг бүлэг гэж үзэх талтай юм.

Зудын гамшиг нь Монголын түүхийн бүхий л хугацаанд олонтоо тохиолдож байсан ба түүний сөрөг үр дагавар нь монгол орны нийгэм, эдийн засгийн салбар бүрт, тэр дундаа хүн амын эрүүл мэнд, шилжилт хөдөлгөөн, хотжилт, ядуурал, ажилгүйдлийн түвшинд улмаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлдөг нийтийг хамарсан гамшигийн төрөл мөн. Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд өнтэй өвөл зөвхөн 8 удаа тохиолдсон, үүнээс сүүлийн 10 гаруй жилийн 2-оос бусад нь 2-16 аймагт мал өвөлжилт хүндэрч байжээ⁴. гэсэн судалгаа байна.

Зуднаар малчин өрхийн мал хэдэн мянгаараа хорогдож, хот суурин газарт нүүдэллэн ирж, хөдөө орон нутгийн хүн ам цөөрч, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөлөөлөл богино хугацаанд мэдэгдэхүйц бус байдал боловч улс орны нийгэм, эдийн засаг болон хүн амын сууршил, шилжилт хөдөлгөөн,

¹ Онцгой байдлын ерөнхий газрын Гамшиг судлалын хүрээлэн онол, практикийн бага хурал. УБ., 2016 он

² Гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал УБ., 2017 он

³ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010 он.

⁴ П.Дамдын. Монгол оронд тохиолддог аюулт үзэгдэл, гамшиг, сургамж. УБ., 2006, х-74

хотжилт, амьжиргааны түвшин, ядууралд урт удаан хугацаанд ноцтой сөрөг үр дагавар. гүн гүнзгий нөлөөлөл үзүүлсээр байна.

Сүүлийн жилүүдэд тохиолдсон зудын сөрөг нөлөөлөл, үр дагаварт эрдэмтэн судлаачид үнэлгээ дүгнэлт хийсэн байна. 1999-2002 оны дараалсан зуд болон 2009-2010 оны зуд хөнөөл, хор уршиг ихтэйд тооцогдсон байна. Гэхдээ 2009-2010 оны зудын малын хорогдлыг оны эхний нийт малын тоонд харьцуулсан эзлэх хувиар үзүүлэхэд улс орны эдийн засагт хүнд цохилт болжээ.

Ган, зудаас мал аж ахуйд учруулсан хохирол¹.

Хүснэгт-1

№	Гамшиг ослын жилүүд	Г амшгийн төрөл	Нэрвэгдсэн аймаг, сумууд	Нийт малын хорогдол (тоо толгой саяар)	
				Тоогоор (том мал)	Хувиар (том мал)
1	1944-1945	Ган, зуд	9 аймгийн 65%	8.1	33.2
2	1954-1955	Зуд	9 аймаг	1.9	8.2
3	1956-1957	Зуд	11 аймаг	1,5	6,2
4	1967-1968	Зуд,гуухай	13 аймгийн 80%	7.8	11.9
5	1976-1977	зуд	15 аймгийн 90%	1.7	8.6
6	1986-1987	зуд	11 аймгийн 80%	0.8	3.6
7	1993	зуд	3 аймгийн 30 сум	1.6	6.4
8	1996-1997	зуд	11 аймгийн 69 сум	0.6	2.1
9	1999-2000	зуд	12 аймгийн 157 сум	3.49	8.9
10	2000-2001	Ган, зуд	13 аймгийн 147 сум	4.75	13.1
11	2001-2002	зуд	13 аймгийн 114 сум	2.91	10.5
12	2009-2010	Ган, зуд	17 аймгийн 95 сум	9.7	22.0
13	2012-2013	Ган, зуд	16 аймгийн 116 сум	2.3	9.6
	2015-2016	Зуд	17 аймгийн 156 сум	1.2	0.5
14	2017	Зуд	15 аймгийн 138 сум	1.8	8.7

Дээрх хүснэгтээр ган, зудаас мал аж ахуйд учруулсан хохирлыг ган, зуд тохиолдсон он жилүүд, зудын төрөл, ган, зудад нэрвэгдсэн, аймаг сумд, нийт малын хорогдлыг тоо толгой, эзлэх хувиар харуулсан байна. Тус хүснэгтээс харахад гантай, зуншлага муутай жилд болсон зуд болон дараалсан жилүүдэд тохиолдсон зудад олон аймаг, сумд хамрагдаж малын хорогдол өндөр байсан байгаа нь байгалийн давагдашгүй хүчин зүйл байсан гэж үзэх үндэстэй. Мөн 1967-1968 онд социализмын үеийн намын хүчтэй үзэл суртал, удирдлага зохион байгуулалт сайтай байсан үед туурайн зуд тохиолдож 13 аймгийг

¹ ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн. УБ., 2011-2017 он.

хамарч 7.8 сая мал хорогдсон нь зудын хавсарсан нөхцөл байдал үүссэн гэж тэмдэглэжээ.

Зудын гамшиг нь улирлын чанартай болдогоороо онцлог юм. 2009-2010 оны зудын улмаас учирсан хохирол 660 тэрбум төгрөг байсан бөгөөд энэ нь цасан ба шороон уурганы хохирлоос 2,5 дахин илүү. бусад төрлийн гамшгийн нийт хохиролтой тэнцэж байгааг судалгаагаар тогтоосон байна.

Зудын гамшгийн үр дагаврыг 2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 6 бүрэлдэхүүн хэсгээс Оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, Дотоодын аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалтай холбон дараах байдлаар авч үзсэн.

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох оршин тогтнохуйн, эдийн засгийн, хүний болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын 8 дэд бүрэлдэхүүн хэсгийн 13 заалтыг хангахад зудын үр дагавар, хүчин зүйлс сөргөөр нөлөөлж болох байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүдэд зудын гамшигт хамаарах байдлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт-
2

№	Аюулгүй байдлын үндсэн хэсэг	Улс орны аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүд зудын гамшигт хамаарах зүйлүүдийн түүвэр	Зудыг гамшгийн хамаарлын төрөл	
			Шууд	Шууд бус
1	Монгол улсын оршин тогтнохуйн аюулгүй байдал	Байгаль, экологийн гамшиг гарах, хүн ба мал, амьтны гоц халдварт өвчин гарч тархах	Шууд	
2	Эдийн засгийн аюулгүй байдал	Инфляц үсрэнгүй нэмэгдэн төгрөгийн ханш унаж, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой айл, өрхийн тоо олшрох, ажилгүйчүүд түүний дотор хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадваргүй хүн амын тоо хэт ихсэх.	Шууд	
3	Мэдээллийн аюулгүй байдал	Бүрэн мэдээлэл өгөхгүй байх буюу худал мэдээлэл өгөх замаар бусдыг хохироох	Шууд	
4	Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал	Архидан согтуурах явдал газар авч хүн амын эрүүл мэнд, удмын санд сөрөг нөлөө үзүүлэх	Шууд	
	Экологийн аюулгүй	Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цөлжилт эрчимжих, хур		

5	байдал	тунадасны тоо хэмжээ, хуваарилалт өөрчлөгдөх, ган зудтай жилийн тоо нэмэгдэх, байгалийн нөөц баялгийг сорчлох, цөмлөх байдлаар ашиглах	Шууд	
6	Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал	Гадаад, дотоод байдлын улмаас нийгэмд оюуны хоосон зай үүсэх, нийгэм оюуны хоосролд орох.		Шууд бус
7	Иргэдийн эрх чөлөөний аюулгүй байдал	Нийгэм эдийн засгийн байдлын улмаас иргэдийн эх оронч сэтгэлгээ алдагдах		Шууд бус

Дээрх хүснэгтэд 2010 оны Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд аюулгүй байдлыг хангахад сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлүүдтэй харьцуулахад зудын сөрөг үр дагавар нь улс орны Оршин тогтнохын аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Хүн амын удмын сангийн аюулгүй байдал, Экологийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх сөрөг хүчин зүйлүүдийг үүсгэх аюултай шууд байдлаар¹ Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, Иргэдийн эрх чөлөөний аюулгүй байдалд шууд бус байдлаар хамааралтай байх үндэстэйг харуулж байна.

Дээрх хүснэгттэй холбогдуулан нэгэн баримтыг авч үзье. 2008 оны 5 дугаар сарын 26-28 өдрүүдэд зүүн аймагууд болох Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр, Төв аймгийн 27 сум, 1 тосгоны нутаг дэвсгэрийг хамарсан хүчтэй цасан болон шороон шуурганы улмаас 254 хүн төөрч, малтайгаа шуурганд уруудсаныг эрлийн групп 202 хүнийг эсэн мэнд олж энэхүү гамшигт үзэгдэлд том хүн, хүүхэд нийлсэн нийт 52 хүн амь насаа алдаж, 350 гаруй мянган мал хорогдож, аймаг, сумыг холбосон цахилгааны 62 тулгуур, холбооны 668 шон унаж цахилгаан, холбоо тасарсан. олон арван хашаа болон барилга байгууламжийн цонх, дээвэр хууларч асар их хохирол учирсан юм. тухайн үед Монгол Улсын засгийн газар, Улсын Онцгой комисс 2 удаа хуралдаж 1 тэрбум төгрөгийн асуудлийг шийдвэрлсэн мөн үхсэн малын сэг зам устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд 640.2 сая, эрэн хайх ажиллагааны зардалд 39 сая төгрөг, цасан болон шороон шуурганд гэр нь нурж эвдэрсэн малчин иргэдэд олгох 163 гэр, хоол, хүнсний материал болон нас барсан хүмүүсийн ар гэрт 55 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж байсан^{1 2}. Энэхүү байгалийн гамшигт үзэгдэл нь богино хугацаанд болж асар их хохирол дагуулж иргэдийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байсан байна.

Урьд өмнөх зудын сургамж болон үр дүнгээс үзэхэд зудын гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг шат

¹ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010 он.

² ОБЕГ. Зүүн аймагуудад тохиолдсон гамшигт үзэгдэл, судалгааны тайлан. УБ., 2008 он.

дараатайгаар авахгүй бол Монгол улсын эдийн засгийн чухал салбар болох бэлчээрийн мал аж ахуйн салбарт их хэмжээний хохирол гарч хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэвийн ажиллагаа, хүн амын амьдралын үндсэн хэрэгцээг хангах явдал алдагдаж, улмаар эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлнэ. Зудын улмаас малаа алдсан малчид ажлын байргүй болж, хот суурин газар нүүдэллэн, хотжилт улам ихсэж ажилгүйдэл, ядуурал, эмзэг бүлэг нэмэгдэж, гэр бүл салах. хүүхэд сургуулиас завсардах, эмэгтэйчүүдийн хүйсийн тэгш байдал зөрчигдөх, архидалт, гэмт хэрэг. зөрчил газар авч, сахилга. дэг журам алдагдаж улмаар нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх болно.

Зудын гамшигт нэрвэгдэж малаа алдсан иргэд сэтгэл санааны хямралд орж, ирээдүйдээ итгэх итгэл алдарч, элдэв эмгэг өвчин тусах зэргээр эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл алдагдан хүний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө. Мал ихээр хорогдсоноор мал, махан бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эдийн үнэ ханш эрс өсч стратегийн хүнсний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэж нийлүүлэлт саарч, хүн амын хүнсний хангамж, чанарын баталгаа алдагдаж хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө. Хот суурин газарт шилжин суурших үйл явц ихэссэнээс хөдөө орон нутаг эзгүйрч, нүүдлийн уламжлалт мал аж ахуй эрхлэх малчин өрхийн тоо багасах, монгол мал маллах ухаан, малчин өв уламжлал, нүүдлийн соёл иргэншил, ёс заншил алдагдан үндэсний соёл иргэншлийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө¹. гэж үзэх үндэстэй болно.

Зудын гамшигийн төрөл, урьдчилан сэргийлэх арга зам:

Малчдын болон тухайн орон нутгийн удирдлагын гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал дутсан үед мал олноор хорогдох нөхцөлийг бүрдүүлж байгаа байгалийн үзэгдлийг үндэслэн зудыг ерөнхийд нь:

1 .Харын зуд

2 .Цагаан /цасан/ зуд

3 .Шуурган зуд

4 .Хүйтний зуд

5 . Хавсарган зуд гэж ангилж болох юм. Гэвч энэ бол зудын тухай ойлголтыг тодруулахын тулд зориуд ангилж байгаа харьцангуй ялгалт юм.

Харын зуд: Хүйтний улиралд удаан хугацаагаар цас огт ороогүй бөгөөд нуур, ихэнх гол мөрөн, булгийн ус хөлдсөнөөс худгийн ус хүрэлцэхгүй мал сүрэг усаар гачигдан мал олноор хорогдох нөхцөл бүрэлдэхийг харын зуд гэнэ. Ийм нөхцөл манай оронд цөөн удаа тохиолдож бага газар нутгийг хамарч байснаас гадна хүйтний улиралд хэд хэдэн сараар цас орохгүй байх нь ховор тохиолддог.

¹ *ШБолдбаатар, Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам.* УБ., 2016., х-46

Харын зуд цастай нутагт нүүдэллэж болох учир бусад зудаас бага хохирол учруулах ба дулаалж тохижуулсан худаг, булаг, харз усаар өвлийн бэлчээрийг хангасан тэр цагт бэрхшээлээс гарч болно. Их хүйтрэх, ялангуяа эрт хүйтрэх нь харын зуд болох гол нөхцөл болдгоос гадна харын зуд болсон цагт ашиглаж байгаа цөөн харз булаг, худгийн ойролцоо олон мал цугларч, бэлчээрээс алслагдах буюу усанд тууварлагдаж, мал улдах, дулаан бууц, хашаа байргүй нутагт хутаглах зэргээс мал богино хугацаанд ихээхэн турах зэрэг нь байдлыг улам хүндрүүлэх ба харын зуд болсон нутагт хөрсний чийг бага байдаг учраас хавар ногоо оройтож ургах зэрэг муу нөлөөтэй болно.

Цагаан /цасан/ зуд: Намар, өвөл, хаврын цагт их хэмжээний цас орж бэлчээрийг цасаар хучсанаас мал бэлчээрээс өвс олж идэх боломжгүй болж малын тэжээл дутагдан олноор хорогдох нөхцөл бүрэлдэхийг цагаан зуд гэнэ.

Ердийн зуншлагатай жилд зонхилох бэлчээрийг бүрхсэн дунд зэргийн нягтралтай, цасны дундаж зузаан хангайн бүсэд 12-15 см, хээрийн бүсэд 8-10 см, говийн бүсэд 5-6 см, болоход мал бэлчээрээс өвс олж идэхэд хүнд болдог байна. Манай оронд цагаан зуд хамгийн олон удаа их хэмжээний газар нутгийг хамран тохиолдож байсны дотор зун нь гантай, зуншлага муу байсны дараах өвөл, хаварт бэлчээрийн тачир өвс цасанд дарагдан далд орж зуд болох нь ердийн зуншлагатай цагт цас их орж зуд болохоос олон тохиолдож байсан бололтой. Цагаан зуд ихэвчлэн их нутгийг хамардаг малын бэлчээр ашиглах боломжийг удаан хугацаагаар алдагдуулан мал олноор цасанд дарагдан үхдэг зэргээс мал аж ахуйд бусад төрлийн зуднаас илүү хохирол учруулдаг.

Гэвч бог мал, үхрийн саравчтай хашаагаар хангаж адуу, тэмээг байнгын хариулга маллагаатай болгосноор малыг цасанд дарагдуулахгүй байж болох ба тэжээлийг нь өргөн тариалж арвин хадлан авч, гүйцэд ашиглах замаар өвөл, хаврын цагт малын суурь, наад зах нь 3 сарын нэмэгдэл тэжээл бэлтгэдэг болсон цагт цагаан зудын бэрхшээлийг давж болох юм.

Шуурган зуд: Хүйтний улиралд шуурга удаан хугацаагаар үргэлжлэн малын бэлчээрт идээшлэх боломжийг алдагдуулснаас дулаан хэвтэр бууц, ялангуяа тэжээл дутагдан мал өлсөж дааран олноор үхэх нөхцөл бүрдэхийг шуурган зуд гэнэ. Хүйтний улиралд 1 секундэд 10 метрээс илүү хурдтай салхи хангайн бүсэд 5 хоног, хээрийн бүсэд 4 хоног, говийн бүсэд 3 хоног дараалан шуурвал дан бэлчээрийн мал бэлчээрээ ашиглаж чадахгүй үхэхэд хүрнэ. Шуурган зуд шиг агаарын байдал эрс өөрчлөгдсөнөөс ихэвчлэн агаар мандлын хүйтэн фронт өнгөрөн гарахад гэнэт тохиолдоно. Шуурган зуд цөөнгүй тохиолдох боловч дангаараа нэг удаа ихээхэн газар нутгийг хамаарч тохиолдох нь ховор байдаг. Шуурган зуд нь ихэвчлэн цагаан зудын хамт их хүйтэнтэй хавсарч тохиолддог. Эл зудны бас нэг муу тал нь урьд орсон цасыг их хагууруулдаг ба хунгарладаг явдал юм. Гэвч богино хугацааны дотор тохиолддог ба урьдчилан мэдээлэх боломжтой тул малаа дулаан хашаа байраар ханган зохих хэмжээний өвс тэжээл бэлтгэснээр зудын бэрхшээлийг давж чадна.

Хүйтний зуд: Хүйтний улиралд мал бэлчээрлэж чадахгүй болтол хэд хэдэн хоногоор их хүйтрэн тэжээл, хашаа дутагдсанаас бэлчээрийн мал өлсөж

дааран олноор үхэх нөхцөл бүрдэхийг хүйтний зуд гэдэг. Хоногийн дундаж температур тухайн сарынхаа дундаж температураас 10 ба түүнээс ихээр, хангайд 10, хээрт 7, говьд 5 хоног дараалан хүйтэн байхад нөмөр хашаа нөөц тэжээлгүй бол мал бэлчээр ашиглаж чадахгүй учир зутарна. Тэгэхдээ хүйтний байдал малд нөлөөлөх нь салхины хурдаас хамааран харилцан адилгүй. Жишээлбэл салхигүй намуухнаар -40 хэмд бэлчээрлэж чаддаг бол хүйтэн салхитайд -30 хэм хүртэл хүйтрэхэд мал бэлчээрт идэшлэж чаддаггүй байна. Хүйтний зуд дангаараа цөөн тохиолдох бөгөөд ихэвчлэн цас шуурганы хамт тохиолддог ба хүйтний улмаас малын хөл, чих, сүүл хөлдөх, хатгалгаа тусах, турах, осгох, хөлдөж үхэх, хээл хаях, ялангуяа төлд муугаар нөлөөлөх зэргээр мал аж ахуйд багагүй хохирол учирч болно. Гэвч дулаан хашаа зохих хэмжээний тэжээлтэй, бэлчээрийг нарийн хуваарьтай ашигласнаар энэ бэрхшээлд автахгүй байх боломжтой.

Хавсарсан зуд: Шуурган, цагаан ба хүйтний зуд эсвэл харын, хүйтний, шуурган зуд буюу тэдгээрийн зарим нь хавсарч бэлчээрийн мал аж ахуйд хохирол учруулан ус, тэжээл, хашаа дутагдсанаас малыг олноор үхүүлэх нөхцөл бүрдэхийг хавсарсан зуд гэнэ. Зудын хэлбэр хэдий олноор хавсарснаас шалтгаалан түүний хор нөлөө янз бүр байх боловч хавсарсан зудын хохирол ерөнхийдөө их байдаг. Гэвч бэлчээрийг хуваарьтай ашиглан малын тэжээлийн бааз, хашаа, саравч, усаар хангаснаар энэ бэрхшээлээс гарч болох талтай. Мөн эрүүл, тарган мал ямар ч зудад илүү тэсвэртэйгээс гадна малыг арчлах малчны ажиллагаа шийдвэрлэх ач холбогдолтой.

Дүгнэлт: Уур амьсгалын дулааралт цаг агаарт нөлөөлсний улмаас ус-цаг агаарын аюултай үзэгдлийн давтамж, учруулах хохирлын хэмжээ өссөн. Мөн сүүлийн жилүүдэд их халалтын улмаас бий болдог орон нутгийн чанартай аюулт үзэгдэлийн давтамжийн тоо нэмэгдсэн.

Малчид, ард иргэдийн байгаль цаг агаарын аюулт үзэгдлийг танин мэдэх, мэргэжлийн байгууллагаас мэдээлсэн аюулт үзэгдлийн мэдээ, мэдээллийг амьдрал ахуйдаа хэрэглэж хэвших, зуд болон байгаль цаг агаарын гаралтай гамшигт үзэгдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аргад суралцах, сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Санал: Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эдгээр үзэгдлүүд нь урьдчилан тааварлах боломжгүй, гэнэтийн шинж чанартай болж байгаатай холбогдуулан цаашид энэ талын судалгааг хөгжүүлж, энэ чиглэлээр Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэмжээнд мэдээллийн нэгдсэн сантай болох шаардлагатай байна.

—ооо—